МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Пүрэвсэнгэ Пүрэв	Дугаар	L335
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Хулд сум
Төрсөн газар	Хулд сум	Төрсөн он	1922
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Олдохын хийд	Сүм хийдийн дугаар	ДУХД 021
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 2	Ярилцлага авсан хүн	Жужа, Энхбаяр

Дундговь аймгийн Хулд сумын Олдохын хийд

Энхбаяр: За та тэгээд Олдохын хийдийнхээ үүх түүхээс ярьж өгнө дөө?

Өвгөн: За би юугаа мэдэхэв дээ , нэг муу банди л явсан.

Жужа: Та одоо нас хэдтэй вэ?

Өвгөн: Аан би одоо 85-ны могойтой хүн дээ.

Жужа: Та хэдэн настай байхдаа лам болсон бэ?

Өвгөн: Өө би ч багаасаа нэг муу банди яваад л өдий хүртлээ л явж байна.

Энхбаяр: Анх та яг хэдэн настай лам болсон бэ?

Өвгөн: Өө мэдэхгүй. Олдохын хийдэд нэг 4,5,6 жил суусан байх.

Жужа: Олдохын ийд хэдэн ламтай байсан бэ?

өвгөн: Аа би нарийн мэдэхгүй. Багцаагаар нэг мянга хүрч байсан байлгүй. Том хийд байсан юмаа уул нь ч.

Энхбаяр: Хэдэн дуган дацантай байсан бэ?

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Өвгөн: За байз, цогчин чойр, жүд, дарь эх, дүйнхор би ч нарийн сайн мэдэхгүй юм аа. Би бага байсан болохоор сайн мэдэхгүй юм аа.

Энхбаяр: Хэдэн жастай байсан бэ?

Өвгөн: Цогчин жас, чойрын жас, жүдийн жас, дүйнхорын жас гэж байсан.

Энхбаяр: Хайлан хурдаг байсан уу?

Өвгөн: Байсан байсан. Ямар зүг байхав.

Энхбаяр: Цам байсан уу?

Өвгөн: Цам ч гардаг л байсан. Нэлээн хэдэн баг л гардаг байсан. Сайхан лам нар цамнаад л.

Энхбаяр: Майдар эргэж байв уу?

Өвгөн: Үгүй ээ майдар эргэж байсан. Цамтайгаа цуг эргэдэг юм уу, би нарийн мэдэхгүй. Зун намар ганжуур эргэж л байсан. Яг нарийныг мэдэхгүй юм. Би тэгэхэд нэг муу бандишуу юм , олигтой мэдэхгүй явж.

Энхбаяр: Таны үед хамба лам нь хэн байсан?

Өвгөн: За би одоо хэлж мэдэхгүй байна. Санахгүй байна.

Энхбаяр: Суварга байсан уу, хэдэн суваргатай байсан?

Өвгөн: Бишгүй л олон суварга байсан, тойроод л .Би одоо нарийн тоог нь хэлж мэдэхгүй юм. Лав л цогчин дуганы зүүн талд чойрын дуган байсан. Жүдийн дуган нь хойно нь байсан юм. Одоо санахаа байжээ. Би одоо ч олигтой хэлж чадахгүй нь ээ. Уг нь мэдвэл ч мэдэх л хүн байгаа юм.

Энхбаяр: Хийд гадууpаа хэрмэн хашаатай байсан уу?

Өвгөн: Аан, гадууpаа тийм битүү сүрхий хашаа ч байгаагүй.

Энхбаяр: Хийдийг дагаж айлууд борчууд хэр байсан?

Өвгөн: Өө айлууд байлгүй дээ, лам нар энэ тэр гээд.

Энхбаяр: Хятадууд байсан уу?

Өвгөн: Өө хятадууд чинь тусдаа, тэр баруунтаа хөндийд байдаг байсан.

Энхбаяр: Сүм дуганууд мод чулуу ер нь юугаар баригдсан байсан бэ?

Өвгөн: За энийг харин би санаж байна. Чойрын дуган нл модон, бусад нь шавар тоосгоор баригдсан байсан. Хятадын бааю гээд нэг юм шавар шатааж байлаа.

Энхбаяр: дуганууд нь дан дуган байсан уу, давахар дуган байсан уу? Аль дуган нь хамгийн том байсан бэ?

Өвгөн: Цогчин дуган л хамгийн том байсан байх. Чойрын дуган гэж сайхан модон дуган байсан. Жүдийн дуган гэж нэг бэсрэг дуган байлаа. Ихэвчлэн дан дуганууд байсан , давхар юм байхгүй.

Энхбаяр: Аль овоогоо тахидаг байв?

Өвгөн: За би тэр овоо тахилганд явж байгаагүй. Сайн мэдэхгүй юм. Тэр зүүн урагшаа байсан Улаан овоог л тахиж байсан санагдаж байна. Нарийн мэдэхгүй юм аа.

Энхбаяр: Хийдийн ойролцоо худаг ус, рашаан, булаг шанд байв уу?

Өвгөн: Жинхэнэ Олдохын ус нь хийдийн баруун талдаа байсан. Авдаг, уудаг ус нь.

Энхбаяр: Энэ худаг уу, булаг уу?

Өвгөн: Худаг, худгийн ус.

Энхбаяр: Нэр алдартай ямар хутагт хувилгаад байсан бэ, Олдохын хийдэд?

Өвгөн: Өө мэдэхгүй мэдэхгүй. Бага байсан болохоор мэдэхгүй.

Энхбаяр: Та ондоо ойролцоо сүм хийдүүдэд бага байхдаа очиж байв уу?

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Өвгөн: Өө үгүй, үгүй. Энэ орон нутаг хийдээсээ өөр газар очоогүй.
Энхбаяр: Олдохын хийд хэдэн онд хаагдсан юм бол?
Өвгөн: Аа мэдэхгүй мэдэхгүй.
Энхбаяр:1937, 1938 оны үед үү?
Өвгөн: Арай бараг өмнө нь ч болов уу.
Энхбаяр: Яаж, ямар байдлаар хаагдсан юм бол?
Өвгөн: Юу гэнэ ээ, чих дүлий болчихоод хүний хэлснийг сонсохгүй зовлонтой юм аа.
Энхбаяр: Зоч лам лүйжин тавьдаг тийм хүн байсан уу?
Өвгөн: Намнангийн Лувсандорж гэж нэг л зоч лам байсан юм. Тусдаа дуган энэ тэр байхгүй ээ. Тусгай нэг их сүрхий байгаагүй.
Энхбаяр: Хийдийн гол шүтээн сахиус нь юу байсан бэ?
Өвгөн: Гол сахиус нь уу, аа би хэлж мэдэхгүй л банйа. Надаас өөр хүн бол хэлэлгүй яахав дээ.
Энхбаяр: Та аль дуганд нь хурдаг байсан бэ?
Өвгөн: Аа би цогчин дуганд л хурдаг байлаа. Чойрт бас хурж л байлаа.
Энхбаяр: Гавжийн дамжаа, гэвшийн дамжаа энэ тэр барьдаг байв уу? Аграмжийн дамжаа энэ тэр гээд?
Өвгөн: Ярьдаг л байсан, сайн мэдэхгүй. Лав л домын дамжаа гавжийн дамжаа гэж барьдаг байсан. Тэр маарамбын дамжааг мэдэхгүй юм, сайн мэдэхгүй байна.
Жужа: Одоо энэ сумын төвд нэг дуган байна. Энэ дуганы тухай та яриач?
Өвгөн: Мэдэхгүй, мэдэхгүй, мэдэхгүй. Би тэнд сууж байгаагүй.
Энхбаяр: Энэ сумын төвөөс ойролцоо Луусын хийд гэж байсан байх юм. Та энэ талаар мэдэх үү?
Өвгөн: Мэдэхгүй ээ мэдэхгүй. / За энэ үед самган нь ярианд оролцож энүүхэн зүүн хойно Луусын хийд гэж байсан юм гэнэ лээ. гэв/
Өвгөн: Би ч одоо хамаг юмаа мартсан, юм сонсохоо байсан. Бүтэлтэй хүн биш ээ.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон